

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны  
12 дугаар сарын 27-ны өдрийн 11:40  
дугаар тушаалын хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан  
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27 11:40

#### Байгууллагын нэр:

Мөрдөн байцаах алба

#### Нэгжийн нэр:

Захиргааны удирдлагын хэлтэс

#### Албан тушаалын нэр:

Өргөдөл гомдол хариуцсан чиглэлийн  
ахлах мэргэжилтэн

#### Албан тушаалын ангилал, зэрэглэл:

TT-5

#### Ажлын цаг:

8 цаг

#### Ажлын байрны албан ёсны байршил:

Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо,  
Самбууугийн гудамж 18

#### Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

#### Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын гоц  
халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад  
аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй  
байдал үүссэн, террорист халдлага, онц  
болон дайны байдал зарласан, онц ноцтой  
гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй  
тохиолдолд уртасгасан цагаар болон  
өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

#### Албан тушаалын зорилго:

Байгууллага, аж ахуйн нэгж иргэдээс Мөрдөн байцаах албанад хандан гаргасан өргөдөл,  
гомдол, хүсэлтийг хүлээн авч бүртгэл, шийдвэрлэлт, хугацаанд хяналт тавих.

- Мөрдөн байцаах албанад ирсэн санал, өргөдөл, гомдол, хүсэлтийг бүртгэж  
шийдвэрлэлтэд хяналт тавих.
- Мөрдөн байцаах албанад ирсэн санал, өргөдөл, гомдол, хүсэлтийн тайланг сар, улирал,  
хагас жилээр гаргах.
- Удирдлагаас хариуцуулсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.
- Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад  
чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 121-д заасан ажлыг хэрэгжүүлэх; 1.2.Албаны даргын өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг холбогдох алба хаагчтай хамтран тооцож, танилцуулах.	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн гаргасан санал, өргөдөл, гомдол хүсэлт хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна.	Г, Х  Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 121-ийн 121.9-д заасан ажлыг хэрэгжүүлэх.	Цагдаагийн төв байгууллагын удирдлага, албаны удирдлагыг нөхцөл байдлын мэдээгээр хангана.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Албаны дарга, удирдлагад шаардлагатай албан бичгийг цаг хугацаанд шилжүүлэн өгөх; 3.2.Дээд шатны байгууллага, албан тушаалтан, удирдах ажилтнаас тусгайлан хариуцуулсан үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх; 3.3.Удирдлагаас хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлж, хууль дүрэм, журамд нийцсэн бусад үүрэг даалгаврыг биелүүлэх. 3.4Хэлтсийн даргын баталсан хуваарь, үүргийн дагуу даалгасан ажлыг зохион байгуулж, дүнг танилцуулах;	Баримт бичиг, албаны ажил цэгцэрнэ.	Г, Х  Г  Г
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд мөрдөх; 4.2.Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ тогтоосон хугацаанд үнэн, зөв мэдүүлэх; 4.3.Авлигын сэжигтэй тохиолдол бүрийг холбогдох албан тушаалтан, байгууллагад мэдээлэх; 4.4.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.	-	Г  Г  Г

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

<b>Боловсрол</b>	Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
<b>Мэргэжил</b>	<ul style="list-style-type: none"> <li>-Эрх зүй /0421/</li> <li>-Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/</li> </ul>		
<b>Мэргэшил</b>	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
<b>Туршлага</b>	Цагдаагийн байгууллагад 8-аас доошгүй жил, үүнээс харьяа нэгжийн болон албаны ахлах, түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.		
<b>Ур чадвар</b>	<b>Дүн шинжилгээ хийх</b>	<ul style="list-style-type: none"> <li>-Мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах;</li> <li>-Нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах;</li> <li>-Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх;</li> <li>-Судалгааны арга зүйн мэдлэгтэй;</li> </ul>	
	<b>Асуудал шийдвэрлэх</b>	<ul style="list-style-type: none"> <li>-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах;</li> <li>-Асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох;</li> <li>-Удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах.</li> </ul>	
	<b>Багаар ажиллах</b>	<ul style="list-style-type: none"> <li>-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;</li> <li>-Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.</li> </ul>	
	<b>Бусад</b>	<ul style="list-style-type: none"> <li>-Монгол хэлний найруулга зүй, зөв бичих дүрмийн мэдлэгтэй байх;</li> <li>-Компьютерын өргөн хэрэглээний программ, дотоод сүлжээнд бүрэн ажиллах чадвартай байх;</li> <li>-Архив, албан хэрэг хөтөлтийн стандартын мэдлэгтэй байх;</li> <li>-Оффисын төхөөрөмжүүд дээр ажиллах чадвартай байх;</li> <li>-Мэдээллийн технологийн болон зайлшгүй шаардлагатай бусад ур чадвар.</li> </ul>	


#### IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

**Албан тушаалтыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:**  
Захиргааны удирдлагын хэлтсийн дарга

<b>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</b>	<b>Бусад харилцах субъект:</b> <b>Шууд харилцах байгууллага:</b> -Мөрдөн байцаах албаны алба хаагчид. -Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагчид. -Бүх шатны шүүх, прокурорын байгууллага, -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, -Шүүхийн шинжилгээний байгууллага. <b>Шууд бус харилцах байгууллага:</b> -Төрийн болон төрийн бус бусад байгууллага, иргэд /Эдгээртэй харилцаадаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.
--	--

#### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

<b>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</b>	<b>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</b>
---	--

<p>Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА</p> <p></p> <p>Т.ГАНЗОРИГ</p> <p>2023 оны 12 дугаар сарын <u>27</u>-ны өдөр</p>	<p>Байгууллагын нэр: .....</p> <p>Шийдвэрийн огноо: .....</p> <p>Дугаар: .....</p>
--	--

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-өдөр  
Дугаар: №1

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

**ТАНИЛЦСАН:**

Албан тушаалтан: .....

.....

20... оны .... дугаар сарын ....-ны өдөр